

### **III БҮЛЭГ. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ, ТАВИГДАХ ШААРДЛАГА**

#### **АЖЛЫН ДААЛГАВАР**

**Ажлын нэр:** Харуул хамгаалалтын үйлчилгээ

**Объектын байрлал:**

Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 6-р хороо, Ард-Аюушийн өргөн чөлөө, П.Н.Шастины Нэрэмжит Улсын Гуравдугаар Төв Эмнэлэг

**Үндсэн үйл ажиллагаа:**

Улсын гуравдугаар төв эмнэлэгийн эзэмшлийн 57,589 м.кв талбай бүхий эмнэлгийн объектууд болон эмнэлгийн эзэмшлийн гадна талбай, түүний эд хөрөнгийг гэмт халдлагаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, хорлон сүйтгэх, гал түймэр, хулгай, дээрэм бусад аюулын мэдээг зохих байгууллагад цаг алдалгүй мэдэгдэх, шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэх харуул хамгаалалтын үндсэн үйл ажиллагааг гүйцэтгэнэ.

**Нэмэлт хийх ажил:**

- Байгалийн үзэгдэл их хэмжээний цас бороо, салхи шуурганы үед хамтарч тусалж ажиллах, харуулын пост нь хариуцсан талбайн цэвэр цэмцгэр байдалд анхаарч, авто зогсоол зохицуулах.
- Шаардлагатай үед байгууллагын дотоод үйл ажиллагаанд оролцох/ Гадны, сэжигтэй, согтууруулах зүйл хэрэглэсэн байж болзошгүй этгээдийг талбайгаас гаргах, болзошгүй гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх.

**Харуул хамгаалалтын байгууллага нь:**

- Харуул хамгаалалтын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрөлтэй, тоног төхөөрөмжөөр бүрэн хангагдсан, хүний нөөц, санхүүгийн чадавхитай байгууллага байна;
- Харуул хамгаалалтын ажилтан нь харуул хамгаалалтын сургалтанд суусан, тусгай шаардлагатай техник хэрэглэл, ажилтны дүрэмт хувцасаар хангагдсан байна;
- Харуулын ажилтан нь ажлын туршлагатай, тусгай багаж хэрэгсэлтэй харьцах чадвартай, ял шийтгэлгүй, ямар нэгэн гэмт хэрэгт холбогдоогүй байх ;
- Харуул хамгаалалтын ажилтнуудыг тогтвортой суурьшилтай ажиллуулах
- Талбайд нэвтрэх, гарах бүхий л хөдөлгөөнийг хяналтад байлгаж бүртгэлжүүлэн ажиллах;
- Объектын талбайд 24 цагийн турш 2 цаг тутамд тойролт хийж объектийн бүрэн бүтэн байдлыг шалгах;
- Талбайд гарсан аливаа зөрчлийг харьяалах албан байгууллагад мэдэгдэж ажиллах;

- Захиалагч байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон харуул хамгаалалтын журмыг хамтран хэлэлцэн баталж, үйл ажиллагаандaa мөрдлөг болгон ажиллана;
- Харуул хамгаалалтын ажилтан нь хяналтын камертай ажиллах чадвартай байх;
- Харуул хамгаалалтын ажилтнууд нь үйлчилгээний байгууллага ажиллах харилцааны соёл, ёс зүйтэй байна;
- Харуул хамгаалалтын ажилтнууд нь тус эмнэлэгт тогтвортой суурьшилтай ажиллах;

## ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХУВААРЬ

- 1. Үйлчилгээний үргэлжлэх хугацаа:** 2024 оны 12 дугаар сарын 31-ны өдөр хүртэл /дараагийн тендерээр шалгарч гэрээ байгуулах хүртэл/
- 2. Үйлчилгээ үзүүлэх хуваарь:** Өдөр бүр 24 цагаар
- 3. Хамгаалах харуул хамгаалалтын объект, постын тоо:** 2

Д/д	Нэр	Ээлжлэх хүний тоо	Ажлын өдөр	Ажиллах цах
1	Харуулын пост №1	3 хүн ээлжлэн тус бүр 24 цагаар солигдон ажиллах	365	24
2	Харуулын пост №2	3 хүн ээлжлэн тус бүр 24 цагаар солигдон ажиллах	365	24